

Япон Улсын Засгийн газар шинэ төрлийн коронавирусийн халдвартай тэмцэх хориг арга хэмжээг чангатган Монгол Улсад доорх арга хэмжээг хэрэгжүүлэх болов.

1. 5 дугаар сарын 14-ний өдрөөс “Хорио цээрийн хяналт шалгалтыг чангатгах улс”-ын жагсаалтад Монгол Улсыг оруулсан.
2. 5 дугаар сарын 18-ны өдрөөс “Халдварын эрсдэлтэй шатлал”-ыг 2 буюу шаардлагагүй тохиолдолд зорчихгүй байх зэрэглэлээс 3 буюу зорчихгүй байхыг анхааруулах зэрэглэлд шилжүүлсэн.
3. 5 дугаар сарын 19-ны өдрөөс “Хилээр нэвтрүүлэхээс татгалзсан улс”-ын жагсаалтад оруулсан.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр 5 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн Япон Улс руу зорчихоос 14 хоногийн өмнө Монгол Улсад зорчсон гадаадын иргэнийг хүндэтгэн үзэх шалтгаангүй бол хил нэвтрүүлэхээс татгалзана. Гэхдээ одоогийн байдлаар хүндэтгэн үзэх шалтгаангүй иргэнд виз олгохгүй байгаа тул Монгол Улсаас Япон Улсад нэвтрэх иргэдийн тухайд өнөөг хүртэлх арга хэмжээнд өөрчлөлт ороогүй болно.

\*Хүндэтгэн үзэх шалтгааныг [эндээс](#) үзнэ үү.

Дэлгэрэнгүй мэдээллийг [Япон Улсын Хилийн шалган нэвтрүүлэх газраас асууна уу](#).

Шинэ арга хэмжээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээс авах боломжтой.

• Япон Улсын хилээр нэвтрүүлэх шинэ арга хэмжээний талаарх Япон Улсын ЭМНХЯамны веб хуудас

(Хилийн хяналт шалгалтын арга хэмжээ)

[https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000121431\\_00209.html](https://www.mhlw.go.jp/stf/seisakunitsuite/bunya/0000121431_00209.html)

• Шинэ арга хэмжээний талаарх Япон Улсын ГХЯ-ны вэб хуудас

Япон хэлээр [https://www.mofa.go.jp/mofaj/ca/fna/page4\\_005130.html](https://www.mofa.go.jp/mofaj/ca/fna/page4_005130.html)

Англи хэлээр [https://www.mofa.go.jp/ca/fna/page4e\\_001053.html](https://www.mofa.go.jp/ca/fna/page4e_001053.html)

• Шинэ арга хэмжээний талаарх Япон Улсын Хилийн шалган нэвтрүүлэх газарын веб хуудас

[http://www.moj.go.jp/isa/hisho06\\_00099.html](http://www.moj.go.jp/isa/hisho06_00099.html)

Япон хэлээр <http://www.moj.go.jp/isa/content/001347330.pdf>

Англи хэлээр <http://www.moj.go.jp/isa/content/001347332.pdf>